

**ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛЬ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/-ЫН ТӨСӨЛД
ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУДААС ИРҮҮЛСЭН САНАЛЫН ТОВЪЁОГ
/2021-2024 ОН/**

	Ирүүлсэн санал	Тусгасан байдал
Боловсролд тэгш хамруулах үндэсний сүлжээ /Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбоо, Түгээмэл хөгжил төв, Харааны бэрхшээлтэй хүүхэд залуусын холбоо, ЧД-ийн Гэгээлэн төв/		
1.	ХБХийг ялгаварлан гадуурхсан тохиолдолд өгөх хариуцлагын арга хэмжээг зааж өгөх	Зөрчлийн хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд тусгасан.
2.	.“боломжит тохируулга” Тухайн хүнд зориулагдсан байх ёстой, Тохируулга хийх, Өөрчлөлт хийх боломжтой байх ёстой	Нэр томъёоны тайлбарт оруулсан
3.	.“түгээмэл загвар” гэснийг бүх хүнд зориулагдсан гэж томъёолох	Саналыг тусгасан.
4.	.“олон нийтэд түшиглэн хамруулан хөгжүүлэх үйлчилгээ”- Хамаарагдаж буй бүлэг гэж нэрлэх. Community - “Хүй олон”, Хамаарагдаж буй бүлэг Олон нийт - Public Хамт олон - Арай бага хүрээний Олон нийт биш. Хамт олноос илүү нийгмийн хэсэг бүлэг юм. Иймд Оновчтой нэрээр нэрших хэрэгтэй.	Олон нийтэд түшиглэсэн гэж томъёолсон
5.	Хөтөч нохойны тодорхойлолт дээр хараагүй хүн гэдгийг хасах. Хөтөч нохой нь зөвхөн харааны бэрхшээлтэй хүнд туслах зорилгоор ашигладаггүй, аутизм, Хэт хөдөлгөөн анхаарал сарнилын эмгэгтэй хүүхдүүдийг тайвшруулах гм зорилгоор ашигладаг тул томъёоллыг өргөн хүрээнд харж хийх хэрэгтэй байна.	
6.	7.1.1.хөгжлийн бэрхшээлтэй хүнд үйлчлэх, тэдний эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй өмчийн бүх хэлбэрийн байгууллагыг хөгжлийн бэрхшээлийн ойлголт, хандлага нэмэгдүүлэх сургалтад 3 жил тутамд хамруулна гэсэн байна. 3 жил гэснийг хасч, энэ хуулийг хэрэгжүүлэхгүй байгаа хувь хүн, хуулийн этгээдийг шаардлагатай тухай бүрт нь сургалтанд хамруулна гэсэн агуулгыг нэмэх	Сургалтад заавал хамруулах хугацааг заасан бөгөөд үүнээс бага хугацаанд сургалтад хамраах боломжтой. Хэрэгжүүлэхгүй бол Зөрчлийн хуулиар хариуцлага тооцно
7.	9.1.1."бүх шатны сургалтын хөтөлбөрт хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, хүний ялгаатай байдал, хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт мэдлэг олгох, эерэг хандлага төлөвшүүлэх агуулга тусгах" гэж найруулах	Боловсролын ерөнхий хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгасан.
8.	Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөнд 9.1.3. "хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлогт нийцүүлэн авьяас билэг, бүтээлч чанар, мэдлэг, оюуны болон бие бялдарын чадварыг	Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 6.10-д тусгахаар санал боловсруулав

	хөгжүүлэх агуулгыг Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөнд тусгах" гэж өөрчлөн найруулах	
9.	9.1.4."бүх шатны боловсролын тогтолцоонд хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох, мэргэжил эзэмших нөхцөлийг бүрдүүлэх хүртээмж, боломжит тохируулгаар хангуулж, дэмжлэг туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулна" гэж өөрчлөн найруулах	Хуулийн төслийн 9.1.3-т тусгав
10.	9.3.2."хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудыг тэдний хүйс, оршин суугаа газар, нийгэм, эдийн засгийн хүчин зүйлээс үл хамааран бүх шатны боловсролд тэгш хамруулах ажлыг ердийн сургуулиудад зохион байгуулах үүргийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хүлээх" гэж өөрчлөн найруулах	9.1.3-д агуулгыг нь багтаав
11.	9.3.3."хөгжлийн бэрхшээлтэй хүн бүх шатны боловсрол, сургалтын байгууллагад суралцахад ДЭМЖИХ үйлчилгээ зайлшгүй шаардлагатай тохиолдолд тухайн байгууллага шийдвэрлэх үүрэгтэй" гэж өөрчлөн найруулах	Саналыг тусгав
12.	10.1.3."сургалтыг хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлог хэрэгцээнд нийцсэн заах арга зүй, арга барил эзэмшсэн багш, сурган хүмүүжүүлэгч зохион байгуулах" гэж өөрчлөн найруулах	Хуулийн төслийн 10.1.1-т агуулгыг тусгасан
13.	10.1.4."хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн сурах идэвхи, санаачилгыг нэмэгдүүлэхэд чиглэсэн, тэдний онцлог хэрэгцээнд нийцүүлэн брайль үсэг, дохионы хэл болон харилцааны бусад арга хэлбэрийг хэрэглэх, орон зай, чиг баримжааны чадвар олгох, зөвлөн туслах дэмжих үйлчилгээ үзүүлэх" гэж өөрчлөн найруулах	Саналыг тусгав
14.	10.1.6."элсэлтийн ерөнхий шалгалтыг хөгжлийн бэрхшээлтэй хүнд нээлттэй, онцлог хэрэгцээ, шаардлагыг нь хангасан хүртээмжтэй орчин, нөхцөлд зохион байгуулах" гэж өөрчлөх	Боловсролын ерөнхий хууль болон энэ хуульд туссан
15.	10.2."Бүх шатны боловсрол, сургалтын байгууллага хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлогт нийцсэн боломжит тохируулга, дэмжих үйлчилгээ, сургалтын орчныг бүрдүүлэх журмыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална" гэж өөрчлөн найруулах.	Хуулийн төслийн 10 дугаар зүйлд агуулга нь туссан
16.	10.3 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлог хэрэгцээнд нийцсэн ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг тухайн сургалтын байгууллагын мэргэжил арга зүйн зөвлөл, эцэг эхийн оролцоотойгоор боловсруулж батална.	10.6.Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 6.10-д заасан төлөвлөгөөг тухайн сургалтын байгууллагын мэргэжил арга зүйн зөвлөл, эцэг эхийн оролцоотойгоор боловсруулж батална гэж тусгасан.
17.	10.4.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлог хэрэгцээнд нийцсэн ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнгийн өөрчлөлтийг сургууль, цэцэрлэгийн удирдлага эцэг, эхийн оролцоотой хэлэлцэж, дүгнэлтийг энэ хуулийн 33.2.1-д заасан комисст хүргүүлнэ.	10.7.Хуулийн 10.6-д заасан төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнгийн өөрчлөлтийг сургууль, цэцэрлэгийн удирдлага эцэг, эхийн оролцоотой хэлэлцэж, дүгнэлтийг энэ хуулийн 33.2.1-д заасан зөвлөлд хүргүүлнэ гэж тусгав

18.	10.10.Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн сургалтын онцлог хэрэгцээг хангах, ном, сурах бичиг, гарын авлага, дохионы хэлний толь бичиг зохиох, хэвлэх, түгээх, засан сайжруулах, брайль болон программ хангамжийг монгол хэл рүү хөрвүүлэх, сургалтын боломжит тохируулга, тоног төхөөрөмжийг худалдан авах болон шаардагдах хөрөнгийг улсын төсөвт тусгах ажлыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцан зохион байгуулна.	Саналыг хуулийн төслийн 10.8-д тусгав
19.	Хуулийн нэрийг "Ялгаатай хөгжилтэй хүний эрхийн тухай" хууль гэж өөрчлөх	Саналыг авах боломжгүй
20.	Хуулийн зорилт дээр ялгаатай хөгжилтэй хүүхэд, насанд хүрэгсэдийн эрүүл мэнд, боловсрол, ажил эрхлэлт, бие даан амьдрахтай холбоотой харилцааг гэж бүр тодотгож өгөх.	Энэ агуулга хуулийн зорилтын "хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд оролцох тэгш эрх, түүнийг хангах, хамгаалах" гэсэн агуулгад багтаж тул нарийвчлах шаардлагагүй
21.	26 дугаар зүйлд эмэгтэйчүүд гэж тодотгохгүй байх	НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенцийн агуулгад нийцүүлэн Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн асуудлыг тусгайлан авч үзсэн
22.	29 дүгээр зүйл дээр Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бие даан амьдрах төв, асран хамгаалагчтай амьдрах дэд бүтцийг бий болгох, авч явах хууль зүйн зохицуулалтыг оруулж өгөх	29-р зүйлийн агуулгад нийцэхгүй байгаа тул саналыг тусгах боломжгүй
23.	30.3 дээр Тусгай олимп орхигджээ. Энэ заавал орох ёстой	Саналыг тусгав
"Элэгсэг оршихуй" ТББ		
24.	Хөгжлийн бэрхшээл бүр сурч боловсрох, ажиллах тал дээр тэгш хүртээмжтэй байх	Энэ санал хуульд туссан
25.	Бэрхшээл бүрт шаардлагатай тусгай хэрэгсэл, эмийг хилээр оруулж байх	Энэ санал хуульд туссан
26.	Хориглосон хэрэглээ болох эмний төрлүүдийг бэрхшээл бүрийн салбарын удирдах байгууллагуудад хариуцуулан ашиг, алдагдалгүй иргэдэд хүргэж байх эрх олгох	Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд хөнгөлөлттэй үнээр авах асуудлыг тусгасан. ТББ эм олгох зохицуулалтыг тусгах боломжгүй
27.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөө байгуулагдсан сангийн орлого, зарлагын тайланг нийтэд нээлттэй мэдээллэх	Энэ агуулга хуульд тусгагдсан
28.	ХНХЯ, ЭМЯ, БХЯ хамтран гэрээ байгуулж хилээр оруулахыг хориглосон эмний тал дээр Зөвшилцлийн гэрээ байгуулан хэрэгцээт хүмүүст нь олгож байх	Эмийн тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай зэрэг холбогдох хууль тогтоомжийг зөрчих тул тусгах боломжгүй
29.	Нийгэмд үүсгэж буй ХБИ-ийн ялгаварлалт байдлыг арилгах, тухайн байдлаас шалтгаалж гаргасан хохирлыг сэтгэл санаа, мөнгөн төлбөрөөр нөхөн төлүүлэх	Энэ хууль болон Зөрчлийн тухай хуульд тусгасан.
Монголын сонсголгүй иргэдийн үндэсний холбоо		
30.	4.1.5."Боломжит тохируулга" гэж хөгжлийн бэрхшээлтэй хүн бусдын адил хүний үндсэн эрх, эрх чөлөөг тэгш эдлэхэд зориулсан нэн	Саналыг тусгасан

	хэрэгцээтэй тоног төхөөрөмж, материал, хэрэгсэл, программ хангамж, орчин нөхцөл, дохионы хэлний хэлмэрч, орчуулагчийн үйлчилгээг;	
31.	4.1.14. “Дохионы хэлний хэлмэрч” гэж ярианы хэлнээс дохионы хэл рүү хөрвүүлэн хэлмэрчилдэг бүрэн сонсголтой хүнийг;	Саналыг тусгав
32.	4.1.15. “Дохионы хэлний орчуулагч” гэж дохионы хэлнээс дохионы хэл рүү хөрвүүлэн орчуулдаг сонсголтой, сонсголгүй, сул сонсголтой хүнийг;	Саналыг тусгав
33.	4.1.16. “Дохионы хэлний хөтөч орчуулагч” гэж хараагүй хэрнээ сонсголгүй хавсарсан бэрхшээлтэй хүнд ярианы хэл болон дохионы хэлнээс дохионы хэл рүү хөрвүүлэн хэлмэрчилдэг бүрэн сонсголтой, сонсголгүй, сул сонсголтой хүнийг;	Саналыг тусгав
34.	9.1.1.бүх шатны сургалтын цөм хөтөлбөр болон нэмэлт хөтөлбөрүүдийг (хос хэлний хөтөлбөр, ганцаарчилсан хөтөлбөр) хөгжлийн бэрхшээлтэй хүний чадамж болон өөрийгөө үнэлэх үнэлэмжийг хөгжүүлж, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт мэдлэг олгох, эерэг хандлага төлөвшүүлэх агуулга тусгах;	Саналыг тусгав
35.	9.1.2.энэ хуулийн 9.1.1-т заасан сургалтын хөтөлбөрүүдийг хөгжлийн бэрхшээлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас санал авч, суралцагчийн нас, хэл соёлын онцлогт тохируулан боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батлан, хэрэгжүүлнэ.	Сургалтын хөтөлбөрийг батлах нь боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын эрх тул саналыг тусгах боломжгүй
36.	9.1.3. хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлогт нийцүүлэн хэл соёл, авьяас билэг, бүтээлч чанар, мэдлэг, оюуны болон бие бялдарын чадварыг хөгжүүлэх агуулгыг сургалтын цөм хөтөлбөрт тусгах;	
37.	9.3.3.хөгжлийн бэрхшээлтэй хүн бүх шатны боловсрол, сургалтын байгууллагад суралцахад хувийн туслах болон дохионы хэлний хэлмэрч, орчуулагчийн үйлчилгээ зайлшгүй шаардлагатай тохиолдолд шаардагдах хөрөнгийг улсын төсөвт тусгах ажлыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцан зохион байгуулна.	Энэ агуулга хуулийн төслийн 9.6-д туссан
38.	9.3.4.хөгжлийн бэрхшээлтэй хүн бүх шатны боловсрол, сургалтын байгууллагад суралцахад хувийн туслах болон дохионы хэлний хэлмэрч, орчуулагчийн үйлчилгээний журмыг хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батална.	Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн “6.6.Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд суралцаж байгаа ялгаатай хэрэгцээтэй суралцагчид хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх журмыг боловсролын, нийгмийн хамгааллын болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.” Гэж заасан. Энэ журамд боловсрол, сургалтын байгууллагад суралцахад хувийн туслах болон дохионы хэлний хэлмэрч, орчуулагчийн үйлчилгээний асуудал тусгагдана.

39.	10.1.4 хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн сурах идэвх, санаачилгыг нэмэгдүүлэхэд чиглэсэн, тэдний онцлог хэрэгцээнд нийцүүлэн брайль үсэг, монгол дохионы хэл болон бичгийн монгол хэлний хосолсон арга зүй болох хос хэлний арга зүй болон харилцааны бусад арга хэлбэрийг хэрэглэх, орон зай, чиг баримжааны чадвар оруулах, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх	Саналыг тусгасан
40.	10.10.Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн сургалтын онцлог хэрэгцээг хангах сургалтын хөтөлбөр, ном, сурах бичиг, гарын авлага, дохионы хэлний толь бичиг зохиох, дохионы хэлийг монгол ярианы хэл рүү хөрвүүлдэг технологи, дуу хураагуур, хэвлэх, түгээх, засан сайжруулах, брайль болон программ хангамжийг монгол хэл рүү хөрвүүлэх, сургалтын боломжит тохируулга, тоног төхөөрөмжийг худалдан авах болон шаардагдах хөрөнгийг улсын төсөвт тусгах ажлыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцан зохион байгуулна.	Саналыг тусгасан
41.	11.1 Монгол дохионы хэл бол сонсголгүй хүний албан ёсны эх хэл мөн.	Хуулийн төслийн 11.1-д тусгасан
42.	11.1.1 Сонсголгүй иргэн бүр монгол дохионы хэлийг сурах, монгол дохионы хэлээр боловсрол эзэмших, мэдээлэл авах, үзэл бодлоо илэрхийлэх, өвлөх, өвлүүлэх, хамгаалах, хөгжүүлэх боломж, нөхцлөөр хангагдах эрхтэй.	Энэ агуулгыг хуулийн төслийн 11.10-д тусгасан
43.	11.1.2 Монгол дохионы хэлийг эзэмших, хэрэглэх, хамгаалах, хөгжүүлэх бодлого боловсруулах, түүний хэрэгжилтийг хангах нь боловсролын асуудал эрхэлсэн төрийн байгууллага болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Хэлний Бодлогын Үндэсний Зөвлөл үүрэг мөн.	Хуулийн төслийн 11.6-д тусгасан
44.	11.1.3 Монгол дохионы хэлний үгжүүлэх, дохиожуулах, дохионы хэлний санг баяжуулах судалгааны ажлыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Хэлний Бодлогын Үндэсний Зөвлөлийн дэргэдэх Орон тооны бус Дохионы Хэлний Хөгжлийн зөвлөл /цаашид “Зөвлөл” гэх/ -ийн гишүүд, эсхүл иргэн, хуулийн этгээдээр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно. Зөвлөлийн ажиллах журмыг тусгайлан батална.	Хуулийн төслийн 11.7-д саналыг тусгасан
45.	11.1.4 Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Хэлний Бодлогын Үндэсний Зөвлөлийн салбар зөвлөл болох Орон тооны бус Дохионы Хэлний Хөгжлийн зөвлөлийн саналыг үндэслэн боловсролын асуудал эрхэлсэн төрийн байгууллага батална.	Хуулийн төслийн 11.7-ын зохицуулалтад хамаарна
46.	11.2 Сонсголгүй иргэний боловсрол эзэмших хэлний арга зүй нь монгол дохионы хэл болон бичгийн монгол хэлний хосолсон арга зүй болох хос хэлний арга зүй мөн.	Хуулийн төслийн 11.8-д тусгасан

47.	11.2.1. Монгол хэлний тухай хуулийн 13.1.4-ийг үндэслэн Хос хэлний боловсролын хөтөлбөрийг хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.	Хуулийн төслийн 11.9-д тусгасан
48.	11.2.2. Монгол хэлний тухай хуулийн 13.1.4-ийг үндэслэн Хос хэлний боловсролын хөтөлбөрийг сургалтын арга зүйд нэвтрүүлэх ажлыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцна.	Хуулийн төслийн 11.9-д тусгасан
49.	11.3 Өмчийн бүх хэлбэрийн байгууллага нь сонсголгүй хүний эх хэл болох Монгол дохионы хэлээр харилцах бүхий л орчин, боломж, дохионы хэлний хэлмэрч, орчуулгын үйлчилгээгээр хангана.	Саналыг тусгасан
50.	11.3.1. Монгол дохионы хэлний хэлмэрч, орчуулагч бэлтгэх сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг батлах ажлыг мэргэжлийн байгууллагуудын саналыг үндэслэн боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.	Хуулийн төслийн 11.4-т тусгасан
51.	11.3.2. Монгол дохионы хэлний хэлмэрч, орчуулгын үйл ажиллагаа эрхлэх, үйлчилгээ үзүүлэх журмыг мэргэжлийн байгууллагуудын саналыг үндэслэн хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.	Хуулийн төслийн 11.5-д тусгасан
52.	13.1.2.хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсролын үйлчилгээ үзүүлэх багш, хэл засалч, хөдөлгөөн засалч, хөдөлмөр засалч, хараа зүйч, сонсголтой болон сонсголгүй дохионы хэлний шинжээч, сонсголгүйн боловсролын мэргэжилтэн, дохионы хэлний хэлмэрч, орчуулагч, брайль бичгийн багш, сэтгэл зүйч, арга зүйч болон хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй ажиллахад шаардлагатай бусад мэргэжилтнийг сургалтын төрийн сангийн зардлаар дотоод, гадаадад сургах асуудлыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага зохион байгуулах;	Боловсролын болон энэ хуулиар уг асуудлыг зохицуулахаар тусгасан
53.	23.1.1.байнгын асаргаа шаардлагатай 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, бүрэн хараагүй, бүрэн сонсголгүй, одой иргэн болон байнгын асаргаа шаардлагатай хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хөгжлийн бэрхшээлтэй хүнд орон сууцны хөлс төлөхөд, хэрэв нийтийн халаалтгүй сууц, гэрт амьдардаг бол түлш худалдан авахад нь жилд нэг удаа мөнгөн тусламж олгох;	Хуулийн төслийн 22.1.1-д тусгасан
54.	29.2.4.дохионы хэлний хэлмэрч, орчуулагчийн үйлчилгээ;	Саналыг хуулийн төслийн 28.2.5-д тусгасан
55.	30.2.3.хөгжлийн бэрхшээлтэй тамирчдыг олимп, паралимп, тусгай олимп, дифлимп, дэлхийн, тивийн хэмжээний олон улсын тэмцээнд холбогдох журмын дагуу шалгаран явахад нь шаардагдах зардлыг	Хуулийн төслийн 29.2-т тусгасан

	улсын төсөвт тусгах ажлыг Биеийн тамир, спортын улсын хороо хариуцан зохион байгуулна.	
Сонсголын бэрхшээлтэй иргэдийн соёлын төв		
56.	“Монгол дохионы хэл гэж ярианы хэлээр харилцах боломжгүй сонсголгүй, хэл ярианы бэрхшээлтэй монгол иргэд өөр хоорондоо бие махбодийн хөдөлгөөнөөр, ялангуяа гарын хөдөлгөөнийг ашиглан харилцах хэлийг хэлнэ. Дохионы хэл нь сонсголгүй хүний төрөлх хэл бөгөөд яриан болон бичгийн хэлтэй эн тэнцүү хэл юм” гэж шинээр нэмэх	Хуулийн төслийн 11-р зүйлд энэ агуулга тусгагдсан
57.	4.1.1.“хөгжлийн бэрхшээлтэй хүн” гэдэгт бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны болон хүмүүсийн хандлагаас шалтгаалан үүссэн бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох боломж нь хязгаарлагдсан хүнийг; гэж шинэчлэх саналтай байна	Энэ агуулга 4.1.1-д туссан
58.	4.1.11.“ариун цэвэр-эрүүл ахуйн материал” гэж хөгжлийн бэрхшээлтэй хүний өдөр тутмын эрүүл ахуйн шаардлагыг хангах, зайлшгүй хэрэгцээтэй материал хэрэгслийг; гэдгийг дахин нягтлах, зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй холбоотой бол 4.1.11.“ариун цэвэр-эрүүл ахуйн материал” гэж шаардлага гарсан тохиололд хөгжлийн бэрхшээлтэй хүн өдөр тутам хэрэглэх, эрүүл ахуйн шаардлагыг хангах, зайлшгүй хэрэгцээтэй материал хэрэгслийг; гэж шинэчлэх. Тэгэхгүй бол ариун цэврийн материал нь зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй хүнд л зориулагддаг гэсэн утга яваад байх шиг. Найруулга дээрээ жаахан анхаарвал.	Эрүүл мэндийн холбогдох хуульд ьтусгах шаардлагатай
59.	7.1.1, 7.1.2 заалтууд ойлгомжгүй байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгуулсан өмчийн байгууллагын талаар дурдаагүй байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд өөрсдөө байгууллага байгуулж эрхээ хамгаалж ажиллаж байхдаа хөгжлийн бэрхшээлийн талаар суралцахын тулд төлбөр төлөх байдал үүсвэл төвөгтэй биш үү?. Өөрсдөө хөгжлийн бэрхшээлтэй хэдий ч өөрсдийнхөө талаар төлбөр төлж суралцах юм болов уу?	Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үйлчлэх байгууллага гэсэн агуулгаар туссан
60.	16 нас хүртлэх насны сонсголгүй хүүхэдтэй эцэг эх нь жилд дунджаар 14 хоногийг дохионы хэл сурахад зарцуулах бөгөөд үүнтэй уялдуулан үндсэн ажлаасаа чөлөө авч болох ба үүнийг зохицуулах зохицуулалтыг тухайн эцэг,, эхийг ажиллуулж буй өмчийн бүх төрлийн байгууллага хариуцна гэх юм уу.Үүнтэй төстэй заалт оруулж сонсголгүй хүүхэдтэй эцэг эхэд дохионы хэл сурахад үзүүлэх Төрийн дэмжлэгийг заавал хуульчлан оруулах нь зөв гэсэн саналтай байна.	Эцэг эхэд нь дохионы хэл сургах асуудыг энэ хуулиар зохицуулах боломжгүй

61.	Сонсголгүй хүүхдүүд суурь боловсролыг дохионы хэлийг бичгийн хэлтэй уялдуулсан байдлаар эзэмших эрхийг сонсголгүй хүүхдийн суралцаж буй сургууль хангах үүрэгтэй гэж тусгах.	Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын хуулиар энэ харилцааг зохицуулж байгаа
62.	Сонсголгүй хүүхдэд хичээл заах багш нь Монгол дохионы хэлийг бүрэн эзэмшсэн байх, багшийн эзэмшвэл зохих дохионы хэлний түвшинг Төрийн эрх бүхий байгууллага батална. гэсэн утгатай заалт нэмэх	Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын хуулиар энэ харилцааг зохицуулж байгаа
63.	Бүх шатны эрүүл мэндийн байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг харъяалал харгалзахгүй үзэх, эмчлэх, хэвтүүлэх эрхийг тусгах.	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хууль болон бусад хуулиар энэ асуудлыг зохицуулж, хэрэгжүүлж байгаа
64.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсрол олгох мэргэжлээр суралцах нөхцөлд тэтгэлэгийг нэн тэргүүнд шийдэх, төгсөөд ажлын байраар хангагдах асуудлыг боловсролын болон хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага зохион байгуулах;	Хуулийн төслийн 10, 15 дугаар зүйлд энэ асуудлыг тусгасан
65.	Энэ заалт нь тодорхойгүй байна. Монгол улсын хуулийн дагуу гэр бүлээ цугцлуулагчид нь Гэр бүлийн тухай хуулинд заасны дагуу хүүхдийн тэгтэгмж төлдөг. ХБХЭТ хуульд орсон энэ давхардсан заалт нь уг хуулийн заалтаас гадна яг ямар эрхийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд олгож байгаа нь ойлгомжгүй байна.	Гэр бүлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан тусгасан
66.	26.1.1.хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрүүл мэндийн асуудал, хэрэгцээг үнэлж, тэдгээрийн онцлогт тохирсон үйлчилгээг орон нутгийн харъяалал харгалзахгүйгээр хүртээмжтэй үзүүлэх; гэж өөрчлөх	Хуулийн төслийн 17.1.3-т тусгасан
67.	44 дүгээр зүйл Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах салбарын ажилтны нийгмийн баталгаа зүйлийн заалтууд нь шууд утгаараа хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах агуулгагүй харагдаж байна. Энэ заалт нь цаад утгаараа “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь хөдөлмөрийн хүнд нөхцөл үүсгэж буй объект” гэсэн санаа агуулж байна гэж санал хэлэхэд тийм утгаар ороогүй энэ заалт нь Төрийн албан хаагчийн тогтвортой ажиллах нөхцөл байдлыг хангах зориулалттай орсон заалт гэсэн тайлбарыг Яамны мэргэжилтэн өгч байсан. Хэрэв төрийн албан хаагчийг тогтвортой ажлуулахыг хүсч байгаа бол Төр өөрийн төрийн албаны хууль, журмаа боловсронгуй болгох, байхгүй бол шинээр батлах гэх мэтээр өөр зохицуулалт хийх нь зөв болов уу.	Хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудлыг хариуцсан салбарт ажиллагчдын нийгмийн баталгааг хангах асуудлыг энэ хуулиар зохицуулна.
ТББ-ууд /Тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоо, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөх үндэсний зөвлөл, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын нэгдсэн холбоо/		
68.	Энэхүү хуулийн зорилт нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, насанд хүрэгсэдийн эрүүл мэнд, боловсрол, ажил эрхлэлт, бие даан амьдрахтай холбоотой харилцааг эрхийг хангах хэрэгжүүлэх,	Ерөнхий агуулга нь хуулийн төсөлд тусгагдсан

	хамгаалах талаар баримтлах зарчим, төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, оролцоо, хариуцлагыг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.	
69.	4.1.3.“Туслагч бүтээгдэхүүн” гэж хувь хүний үйлдэл, бие даасан байдлыг сайжруулах, эсхүл хэвийн хэмжээнд нь хүргэх зориулалттай хиймэл эрхтэн, туслагч хэрэгсэл, тоног төхөөрөмж, мэдээлэл харилцааны технологи зэрэг бүх төрлийн бүтээгдэхүүнийг;	Туслах технологи гэсэн нэр томъёог тусгасан
70.	Хуулийн нэрийг "Ялгаатай хөгжилтэй хүний эрхийн тухай" хууль гэж өөрчлөх. Disabled буюу бэрхшээлтэй гэдэг үгийг олон орон хэрэглэхээ болж Differently abled буюу ялгаатай хөгжил гэдэг нэршлийг хэрэглэх философи явж байгаа. Иймээс хуулийн нэр томъёогоо дахин эргэн харна уу.	Саналыг авах боломжгүй
71.	4.1.11. “ариун цэвэр-эрүүл ахуйн материал” гэж хэвтэрийн болон байнгын асаргаанд байдаг хөгжлийн бэрхшээлтэй хүнд өдөр тутам хэрэглэгдэх живх, катетр, катетрийн уут, ариутгалын уусмал, ороох боох материал, хэрэгсэл;	Эрүүл мэндийн салбарын холбогдох хууль тогтоомжид тусгах шаардлагатай
72.	“бие даан амьдрах эрх” гэдэг нь хэнтэй, хаана, хэрхэн амьдрах, хэрхэн нийгэмд оролцохоо сонгож, шаардлагатай дэмжлэг авах боломжоор хангагдах эрхийг;	Ерөнхий агуулга нь хуулийн төсөлд тусгагдсан
73.	7.1.7. Хөгжлийн бэрхшээлтэй хүний асран хамгаалагч, харгалзан дэмжигч нарт хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг таниулах, мэдлэг ойлголт өгөх сургалтын хөтөлбөрийг гаргаж, сургагч багш нарыг үндэсний хэмжээнд бэлтгэх	
74.	15.1.2.өөртөө ажлын байр бий болгосон хөгжлийн бэрхшээлтэй хүнд шаардагдах ажлын багаж, тоног төхөөрөмж, материал болон бусад шаардлагатай хэрэгслийг худалдан авахад нь Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийг дэмжих сангаас (ХБХХДС) нэг удаа санхүүгийн дэмжлэг үзүүлэх;	Хуулийн төслийн 7.1.4-т туссан
75.	15.1.4.Мэргэжлийн ур чадварын бүс, тив, дэлхийн тэмцээнд оролцох эрх авсан хүнд ХБХХДсангаас дэмжлэг үзүүлэх;	Саналыг тусгасан
76.	15.1.7.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхэлж байгаа бизнес, тэдний үүсгэл, санаачилгаар байгуулагдсан аж ахуйн нэгжийг санхүүгийн болон хууль тогтоомжид заасан бусад нөхцөлөөр ХБХХД Сангаас болон ЖДҮД сангаас дэмжлэг үзүүлэх	Саналыг тусгасан
77.	17.5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон өсвөр насны охид хөвгүүдэд нөхөн үржихүйн эрүүл мэндийн мэдлэг боловсролыг хүртээмжтэй хэлбэрээр хүргэх хүртээмжтэй сургалтын гарын авлага материал хэрэгслийг бий болгох.	17.1.3-т тусгасан

78.	17.6. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон өсвөр насны охид хөвгүүдэд нөхөн үржихүйн эрүүл мэндийн мэдлэг боловсролыг олгох эмч мэргэжилтэн, үе тэнгийн сургагч багш нарыг бэлтгэн чадавхжуулах	17.1.3-т тусгасан
79.	23.20. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хотын дотор болон хот хооронд хөнгөлөлттэй нөхцөлөөр зорчиход зориулагдсан төсвийг тэдэнд өөрсөнд нь олгож (цахим хэлбэрээр), сонголттой нөхцөлөөр зорчих боломжийг зохион байгуулах	Унааны хөнгөлөлтийг иргэнд шууд олгох боломжгүй бөгөөд хуулийн төслийн 22.1.2, 22.1.3, 22.3-т нийтийн тээврээр зорчих асуудлыг тусгасан
80.	26 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн эрх гэснийг Жендерийн эрх тэгш байдал ба хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн эрх гэж өөрчлөх	Хөгжлийн бэрхшээлтэй хүний жөндөрийн эрх тэгш байдал гэж өөрчилсөн
81.	26.1.1-26.1.3 хүртэлх заалтын эмэгтэйчүүд гэдгийг иргэд болгох	Саналыг тусгасан
82.	26.1.4. Хөгжлийн бэрхшээлтэй охид эмэгтэйчүүдийг бүх хэлбэрийн хүчирхийлэл, доромжлолоос хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх	Саналыг тусгасан
83.	26.1.5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний бэлгийн эрхийг хангах, хүний эрхэд суурилсан олон улсын жишиг үйлчилгээг бий болгоход төрөөс дэмжлэг үзүүлэх гэж нэмэх	Саналыг тусгасан
84.	26.1.6. Нярай хүүхдээ асарч буй хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд туслах үйлчилгээгээр хангагдах, эсвэл хүүхэд асрагч авч ажиллуулахад санхүүгийн дэмжлэг үзүүлнэ гэж нэмэх	Хувийн туслахын үйлчилгээ авч болно
85.	26.1.7. Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн нийгмийн давхар алагчлалд өртөж байдгийг харгалзан үзэж орлого олох, ажлын байраар хангагдахад нь тусгайлан дэмжих үйл ажиллагааг зохион байгуулах гэж нэмэх	Саналыг тусгасан
86.	29 Хөгжлийн бэрхшээлтэй хүн нийслэл, хот хооронд харьяалал харгалзахгүйгээр нийтийн тээврийн хэрэгсэлээр /таксинаас бусад/-ээр 50 хувь хөнгөлөлттэй зорчих, харин асран хамгаалагчийг үнэ төлбөргүй зорчих зохицуулалтыг хий гэж нэмэх	Эмнэлэгт үзүүлэхэд 1 удаа хот хооронд үнэ төлбөргүй зорчих гэсэн зохицуулалт туссан
87.	31.6 Хөгжлийн бэрхшээлтэй уран бүтээлч уран бүтээлээ олон нийтэд үзүүлэхэд шаардлагатай байр талбайн түрээсийн төлбөрт хөнгөлөлт үзүүлэх гэж нэмэх	Хуулийн төслийн 30 дугаар зүйлд туссан
88.	31.7 Соёл урлагийн бүтээлийн ХБХ хүртээмжтэй хэлбэрт шилжүүлэхэд шаардагдах хөрөнгийг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын жил бүрийн төсөвт тусган шийдвэрлэнэ гэж нэмэх	Хуулийн төслийн 30 дугаар зүйлд туссан
89.	32.3 Хөгжлийн бэрхшээлийг хамруулсан гамшгийн эрсдлийг бууруулах төлөвлөгөөг гаргах гэж нэмэх	Саналыг тусгасан
90.	32.4 Онцгой байдлын үе, гамшгаас хамгаалах байрны хүртээмжийг ХБХ-т хүртээмжтэй болгох гэж нэмэх	Саналыг тусгасан
91.	ICF ангилалыг нэвтрүүлэх тухай заалтаа тодорхой болгох - Өвчний жагсаалтаар гаргах - Үйлдлийн хязгаарлалтаар гаргах –аль нэгийг сонгох	Хуулийн төслийн 32 дугаар зүйлд тусгасан

	-ХБ-тэй эсэхийг хэн тодорхойлохыг тодорхой болгох -Магадлах комисс уу -Чадвар алдалтын комисс уу	
92.	Агентлагийг тохируулагч агентлаг болгох (сургалт явуулах гэх мэтийг хасах) -Чадвар алдалтын комиссоо ажиллуулах -Хүртээмжийн комиссоо томилох	Энэ хуульд тохируулагч, хэрэгжүүлэгч агентлагийг тусгах боломжгүй
93.	ХБ-тэй хүн эрх нь зөрчигдсөн бол өөрөө гомдол гаргана, эсвэл төлөөллийн байгууллага гомдол гаргахаар тусгасан-Үүнд төлөөлөн өмгөөлсөн ТББ нь хохирлыг тодорхой хувийг авдаг тогтолцоог нэмэх-Гэрээлэн гүйцэтгэхээр ---Төрд хамааралтай асуудлаар ажиллаж байгаа болохоор	Энэ саналыг тусгах боломжгүй
94.	9.3.3.хөгжлийн бэрхшээлтэй хүн бүх шатны боловсрол, сургалтын байгууллагад суралцахад дэмжих үйлчилгээг зайлшгүй шаардлагатай тохиолдолд тухайн байгууллага шийдвэрлэх үүрэгтэй гэж өөрчлөх	Саналыг тусгасан
95.	15.1.6.хөгжлийн бэрхшээлтэй хүнд мэргэжлийн чиг баримжаа, ур чадвар олгох, хөдөлмөрт бэлтгэх, аж ахуй эрхлэх чиглэлээр сургалт явуулдаг байгууллагад төрөөс дэмжлэг үзүүлэх журмыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцна гэж өөрчлөн найруулах.	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн үйл ажиллагааг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулиар зохицуулна.
96.	16.4.Ажил олгогч хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажлын байрны сонгон шалгаруулалтад оролцоход шаардлагатай боломжит тохируулгаар хангах үүрэгтэй гэж өөрчлөх	Саналыг тусгав
97.	22 дугаар зүйл. Нийгмийн хамгаалал хүртэх эрх 22.1.2.хөгжлийн бэрхшээлтэй эцэг, эх хүүхдээ өсгөн хүмүүжүүлэхэд нь шаардлагатай дэмжлэг үзүүлж, хувийн туслахын үйлчилгээ авах боломжоор хангах гэснийг хасах	Саналыг тусгав
98.	22.2.4.хөгжлийн бэрхшээлтэй хүнд буцалтгүй болон хөнгөлөлттэй нөхцөлөөр орон байр олгох, орон байрныхаа нөхцөлийг сайжруулах журмыг Засгийн газар батална гэж өөрчлөх	Хуулийн төслийн 21.3.2-т энэ агуулгыг тусгасан
99.	23.1.7.б.хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг болон байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүнийг асран халамжилж буй нэг иргэнд 50 хувь гэж өөрчлөх	Саналыг тусгасан
100.	23.1.3.үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас туслах бүтээгдэхүүн хийлгэх, сэргээн засалттай холбогдсон хөнгөлөлт авах эрх үүсээгүй хөгжлийн бэрхшээлтэй иргэний дотоодод хийлгэсэн протез, ортопедын үнийг гурван жил тутам нэг удаа жишиг үнийг баримтлан нөхөн олгох гэж өөрчлөх	Саналыг тусгасан
101.	29.1. 16-аас дээш насны Хөгжлийн бэрхшээлтэй хүн бие даан амьдрах эрхтэй гэж өөрчлөх	18-аас дээш насны гэж тусгасан

102.	29.2.1.хувийн туслах 29.2.2.зөвлөлдөх бүлэг буюу харилцан суралцах (ганцаарчилсан болон бүлгийн) 29.2.3.сургалт, мэдээлэл; 29.2.4.амьдралын итгэл үнэмшил, бие даан амьдрах мэдлэг чадвар олгох зорилгоор түр байрлуулах гэж өөрчлөх	Хуулийн төслийн 28.2-т тусгасан
103.	29.7.Хувийн туслах үйлчилгээ үзүүлэх ажилтанг бэлтгэх сургалтын зардалыг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжүүлнэ гэж нэмэх	Саналыг тусгасан
104.	32.3.Хөгжлийн бэрхшээлтэй хүний бие даан амьдрахад дэмжих (29.2.1) үйлчилгээг ямар ч цаг үе нөхцөл байдалд тасалдуулахгүй авах боломжийг хангах. Байгалийн гамшиг, давагдашгүй хүчин зүйлүүд болон цар тахлын улмаас тавигдах хөл хорио, улс төрийн өөрчлөлт шинэчлэл, ажил хаялт, бүх нийтийн амралт, баяр ёслолын өдрүүдээс үл хамааран үйлчилгээг тасралтгүй явагдах гэж нэмэх	Саналыг тусгасан
105.	35 дугаар зүйл. Засгийн газрын чиг үүрэг 35.1.5.хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг дээдлэгч байгууллага хувь хүнийг жил бүр шалгаруулах журмыг хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлан хэрэгжүүлэх гэснийг хасах	Саналыг тусгасан
"Монголын сонсголгүй иргэдийн үндэсний холбоо"		
106.	10.1.1.Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийг онцлог хэрэгцээнд нь тохирох сурах бичиг, гарын авлага, материал, боломжит тохируулга бүхий хүртээмжтэй орчин нөхцөл, сургалтын тоног төхөөрөмж, хэрэгсэл, туслах хэрэгсэл бүхий дотуур байраар хангах; 10.1.2.Сонсголгүй суралцагчид (ЕБС, Их сургууль) Дохионы хэлний хэлмэрч болон бичгийн тэмдэглэл хөтлөгчтэйгээр хичээлийг агуулга, лекц, бүхий л мэдлэгийг олж авах боломжит нөхцлийг бүрдүүлж, Дохионы хэлний хэлмэрч, бичгийн тэмдэглэл хөтлөгчийн цалин, ажлын нөхцөл, нийгмийн асуудлыг хуулинд оруулах:	Саналыг тусгасан
107.	-Дохионы хэлний орчуулгын үйлчилгээ нь сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүнд саадгүй, тэгш, чанартай, хүртээмжтэй байна. Дохионы хэлний орчуулгын үйлчилгээ нь монгол дохионы хэлээр харилцах нөхцлийг бүрдүүлж, дохионы хэлний хэлмэрч, орчуулгын үйлчилгээгээр хангах төсөв зардлыг хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хариуцна -Өмчийн бүх хэлбэрийн байгууллага нь бүхий л үйл ажиллагаагаа хүн бүрт хүртээмжтэйгээр зохион байгуулах, сонсголын бэрхшээлтэй хүн үйл ажиллагаанд нь оролцвол дохионы хэлний хэлмэрчийн	Саналыг тусгасан

	<p>үйлчилгээгээр хангах,хэлмэрчийн ажлын хөлсийг үйл ажиллагааны төсөвтөө тусгаж, шийдвэрлэж ажиллана.</p> <p>-Сонсголын бэрхшээлтэй иргэдэд шаардлагатай бодит цагийн хадмал тайлбарыг дамжуулагч мэргэжилтэн бэлтгэх зардлыг хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална</p>	
108.	<p>16.1.6 Яаралтай түргэн тусламж, гэнэтийн осол,төрөлт, хүнд хэлбэрийн хагалгаанд орох заалттай сонсголын бэрхшээлтэй хүнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхдээ дохионы хэлмэрчээр хангах</p> <p>16.1.7 Энэ хуулийн 16.1.6-т заасан тусламж, үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах дохионы хэлмэрчийн зардлыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төсөвт жил бүр тусган, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлнэ.</p>	Саналыг тусгасан
109.	<p>17.1.4.Хөгжлийн бэрхшээлтэй хүний туслах бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх, сүүлийн үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлэх</p> <p>17.1.5.Хөгжлийн бэрхшээлтэй хүний туслах технологи, сүүлийн үеийн дэвшилтэт бүтээгдэхүүнийг ашиглах, хэрэглээнд нэвтрүүлэх,суурилуулах зорилгоор гадны улссад туршлага судлах, энэ чиглэлийн мэргэжилтэн, хүний нөөцийг бэлтгэх</p> <p>17.1.6. Хөгжлийн бэрхшээлтэй хүний туслах бүтээгдэхүүнийг нэвтрүүлж буй хувь хүн, байгууллагыг тээвэр болон гаалийн албан татвараас чөлөөлөх,хөнгөлөлт үзүүлэх</p>	Саналыг тусгасан. Зарим санал одоогийн хэрэгжиж байгаа хууль тогтоомжоор хэрэгжиж байгаа
110.	21.1.6.бүрэн хараагүй, бүрэн сонсголгүй, бүрэн хэлгүй /ХАСАХ/ сонсголын бэрхшээлтэй, хэл ярианы бэрхшээлтэй, уруул тагнай сэтэрхий хүний харилцаа холбооны зардалд хөнгөлөлт үзүүлэх;	22.1.8-д туссан.
111.	22.2 Төрөөс хөгжлийн бэрхшээлтэй хүн шаардлагатай хууль зүйн зөвлөгөө, өмгөөлөл, сэтгэл зүйн тусламж үйлчилгээг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу үнэ төлбөргүй хангагдах нөхцөл бололцоог бүрдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлнэ	Саналыг тусгасан
112.	22.4 Шүүх, прокурор, цагдаа, өмгөөлөл, хууль сахиулах байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй хүн эрх ашгаа хамгаалахад хүртээмжтэй орчныг бүрдүүлэх үүрэгтэй бөгөөд үйлчилгээ үзүүлэхдээ текст уншигч, бичигч, дохионы хэлний хэлмэрч, орчуулагчаар үнэ төлбөргүй хангана	Саналыг тусгасан
113.	30.1.4.Сонсголын бэрхшээлтэй иргэн байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюулаас сэрэмжлэх, урьдчилан сэргийлэхэд шаардлагатай	Саналыг тусгасан

	дохиоллын төхөөрөмж болон бусад туслах бүтээгдэхүүнээр хангагдах эрхтэй.	
114.	30.1.5.Сонсголын бэрхшээлтэй хүний онцгой байдлын үед ашиглах дохиоллын төхөөрөмж, туслах бүтээгдэхүүн авах зардлыг холбогдох хуульд заасны дагуу Үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын, Эрүүл мэндийн даатгалын, Нийгмийн халамжийн сангаас тус тус санхүүжүүлнэ.	Үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын, Эрүүл мэндийн даатгалын, Нийгмийн халамжийн сангаас санхүүжүүлэхгүй тул саналыг тусгах боломжгүй
115.	38.1.3.холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй орчин бүрдүүлэх, хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх /нэмэлт/;	Саналыг тусгасан
116.	29.2.Соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага дараахь арга хэмжээг хэрэгжүүлж, шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөвтөө тусган шийдвэрлэнэ:	Зөвхөн сонсголын бэрхшээлтэй биш хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн соёл, урлагийн үйл ажиллагааг дэмжих зохицуулалтыг тусгасан.
117.	29.2.7 Соёл урлагийн бүс, тив, дэлхийн чанартай тэмцээн, уралдаан, Мэргэжлийн ур чадварын олон улсын тэмцээнд оролцох сонсголын бэрхшээлтэй тамирчдад үйлчлэх дохионы хэлмэрчийг оролцогчдын тооноос хамаарч дохионы хэлмэрчээр хангах	
118.	29.2.8 Тэмцээнд уралдаанд оролцох сонсголын бэрхшээлтэй тамирчдад үйлчлэх дохионы хэлмэрчийн зардлыг тухайн жилийн төсөвт суулгаж зардлыг батална.	
119.	4.1.13.“Дохионы хэлний хэлмэрч, орчуулагч” гэж сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүнд ярианы хэлнээс дохионы хэл рүү, дохионы хэлнээс ярианы хэл рүү, дохионы хэлнээс дохионы хэл рүү хөрвүүлэн хэлмэрчилдэг хүнийг;	Саналыг тусгасан
120.	4.1.14 “Хадмал тайлбар бичээч” гэж хаалттай болон нээлттэй тайлбар, бодит цагийн тайлбарыг дамжуулахаар бэлтгэгдсэн мэргэжилтнийг, /шинээр оруулах хүсэлтэй/	Саналыг тусгах боломжгүй
Түгээмэл хөгжил ТББ		
121.	4.1.5.“боломжит тохируулга” гэж тухайн тодорхой хөгжлийн бэрхшээлтэй хүн бусдын адил хүний үндсэн эрх, эрх чөлөөг тэгш эдлэхэд зориулсан нэн хэрэгцээтэй тоног төхөөрөмж, материал, хэрэгсэл, программ хангамж, орчин нөхцөл, үйлчилгээг; / дараах байдлаар найруулах санал байна/	Шаардлагатай тохируулга гэсэн агуулгаар тусгагдсан
122.	23.1.7.б.хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг болон байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүнийг асран халамжилж буй нэг иргэнд 50 хувь/	Саналыг тусгав
123.	27.1. 18 ба түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй хүн бие даан амьдрах эрхтэй. /Гэж өөрчлөх /	Саналыг тусгав
124.	27.2.2. дэмжих бүлэг буюу харилцан суралцах	Саналыг тусгав

125.	27.2.2 ¹ . сургалт мэдээлэл, зөвлөгөө өгөх үйлчилгээ	Саналыг тусгав
126.	27.4.Энэ хуулийн 27.2.1-т заасан хувийн туслах үйлчилгээ үзүүлэх ажилтныг бэлтгэх сургалтын зардал болон хувийн туслахын цалин хөлсийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан болон нийгмийн халамжийн сангаас санхүүжүүлнэ.	Саналыг тусгав
127.	27.16.Хөгжлийн бэрхшээлтэй хүн бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэх үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн оролцоог бүрэн хангасан хуулийн этгээд үзүүлж болно.	хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн оролцоог бүрэн хангасан хуулийн этгээд гэсэн хуулийн нэр томьёо байхгүй учир тусгах боломжгүй
128.	27.17. 5000 мянга ба түүнээс доош хүн амтай сум, тосгонд энэ хуулийн 27.2.1 заасан үйлчилгээг иргэн үзүүлж болно. Тухайн иргэн нь энэ хуулийн 27.16. заасан хуулийн этгээдийн ажилтан байж бэлтгэгдсэн хүн байна.	Саналыг тусгах боломжгүй
Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн холбоо		
129.	“хөгжлийн бэрхшээлтэй хүн” гэдэгт бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь биет мэдээллийн хандлагын институцын саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох боломж нь хязгаарлагдсан хүнийг;	Саналыг тусгав
130.	“боломжит дээд хэмжээ” гэж амьдралын чанарыг сайжруулахад чиглэсэн тухайн хүний чадварыг нь сэргээх, нэмэгдүүлэх дээд хэмжээг; гэж өөрчлөх	Саналыг тусгах боломжгүй
131.	“урьдчилан сэргийлэх” гэж өмчийн бүх хэлбэрийн байгууллага, иргэн, хамт олны оролцоотойгоор өвчин эмгэг, осол гэмтлийн эрсдэлээс хамгаалах нөхцөлийг бүрдүүлэх, мэдээлэл, сургалт сурталчилгаа явуулах, өвчин эмгэгийг эрт илрүүлж эмчлүүлэх, тэдгээрээс үүдэн гарах эрүүл мэндийн болон нийгэм, эдийн засгийн сөрөг үр дагаврыг бууруулах үйл ажиллагааг;	Саналыг тусгаагүй
132.	4.1.14.Дэмжих үйлчилгээ 4.1.15. Ялгаатай хэрэгцээ эсвэл хөглийн бэрхшээлтэй хүний онцлог хэрэгцээ 4.1.16 Ажлын байрны дадлагажуулагч	4.1.11-т Ажлын байрны дадлагажуулагчийг тусгасан
133.	Биет саад, саадгүй гэдэгт 4 төрлийн саадгүй байлгахыг ойлгох уу, саад гэдгийг зөвхөн биет саад гэж ойлгогдохоор байна. Иймд тодорхойлолт дээр заавал саадын талаар тайлбар байх ёстой	Саадгүй байдлын тухай хуульд тусгана
134.	Өмчийн бүх хэлбэрийн байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нийгмийн бүхий л харилцаанд эрх тэгш, бүрэн дүүрэн, үр ашигтай оролцохыг баталгаажуулах зорилгоор тэднийг боломжит тохируулгаар хангах, саадгүй байдлыг бүрдүүлэх арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлнэ	Саналыг тусгав

135.	Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үйлчлэх, тэдний эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй өмчийн бүх хэлбэрийн байгууллагыг хөгжлийн бэрхшээлийн ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх сургалтад хагас жил тутамд хамруулна	Саналыг тусгав
136.	Иргэн, өмчийн бүх хэлбэрийн байгууллага нь ажилтан, албан хаагчдынхаа дунд хүний эрх, хөгжлийн бэрхшээл, хүний ялгаатай байдал, нийгмийн тэгш оролцооны талаарх мэдлэг ойлголт, нэмэгдүүлэх сургалт, сурталчилгааг зохион байгуулна;	Саналыг тусгав
137.	9.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүн бусад иргэний хамт сурч боловсрох, мэргэжил эзэмших эрхтэй бөгөөд энэхүү эрхийг нь хангах чиглэлээр боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:	Саналыг тусгав
138.	9.1.1-ийг хасах	Саналыг тусгав
139.	9.1.2 хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тухайн бэрхшээлээс нь үл хамаарч бүх шатны боловсролын сургалтын байгууллага нь сурч боловсрох, мэргэжил эзэмшихэд боломжит тохируулгаар хангаж, саадгүй, хүртээмжтэй орчин нөхцөлийг бүрдүүлэн бүрэн хамруулах;	Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын хуульд туссан
140.	9.1.3.хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуусыг тэдний нас, хүйс, оршин суугаа газар, нийгэм, эдийн засгийн хүчин зүйлээс үл хамааран бүх шатны боловсролд тэгш хамруулах, шаардлагатай тохиолдолд суралцагчийн онцлог, хэрэгцээг харгалзсан ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг тухайн СӨБ, ЕБС-ийн дэмжлэгийн баг эцэг, эх, асран хамгаалагчийн оролцоотойгоор боловсруулж хэрэгжүүлэх, тэдний хэрэгцээнд нийцсэн дэмжих үйлчилгээгээр хангах ажлыг зохион байгуулах;	Боловсролын ерөнхий хууль болон Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын хуульд туссан
141.	9.1.4.энэ хуулийн 9.1.3-т заасан ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнгийн өөрчлөлтийг сургууль, цэцэрлэгийн дэмжлэгийн баг эцэг, эх, асран хамгаалагчийн оролцоотой хэлэлцэж, дүгнэлтийг тухайн орон нутгийн боловсрол шинжлэх ухааны газар, боловсролын хэлтэс болон энэ хуулийн 31.2.1-д заасан комисст хүргүүлэх	Саналыг тусгав
142.	9.2. Бүх шатны боловсролын сургалтын байгууллага нь энэ хуулийн 31.2.1-д заасан комиссын шийдвэрээр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд шаардлагатай тохиолдолд хөгжлийн цогц дэмжлэгийг үзүүлэх орчныг бүрдүүлж, бэлтгэл ажлыг ханган, боловсрол эзэмшүүлнэ.	Саналыг тусгав
143.	9.4.Бакалавр, Магистр, докторын зэрэг хамгаалахаар суралцаж буй 50-иас дээш хувиар хөдөлмөрийн чадвараа алдсан хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн төлбөрийг төрөөс нэг удаа 100 хувь хариуцна.	Саналыг тусгав

144.	10.1.1.хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийг ялгаатай хэрэгцээнд нь тохирох сурах бичиг, гарын авлага, материал, боломжит тохируулга бүхий хүртээмжтэй орчин нөхцөл, сургалтын тоног төхөөрөмж, хэрэгсэл, дотуур байраар хангах;	Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын хуульд туссан
145.	10.1.2.хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид танхимын, танхимын бус буюу зайн, дэмжигч, явуулын багшийн, цахим сургалт болон эдгээрийн хосолсон хэлбэрээр зохион байгуулж болно.	Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын хуульд туссан
146.	10.1.4.элсэлтийн, анги дэвших болон түвшин тогтоох шалгалтуудыг өгөхөд хөгжлийн бэрхшээлтэй хүний ялгаатай хэрэгцээг харгалзан саадгүй байдлыг хангах	Хуулийн төслийн 10.1.2-т тусгав
147.	10.1.6.боловсролын сургалтын байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй оюутныг ажил олгогчдод танилцуулах, ажлын байранд зуучлах, хөдөлмөр эрхлэх, мэргэжлээ сонгоход нь туслалцаа үзүүлэх;	Хөдөлмөр эрхлэлтийн зуучлах үйлчилгээ тул энэ хуулиар зохицуулах боломжгүй
148.	10.2.Элсэлтийн шалгалтад тэнцэж дотоодын их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн боловсролын байгууллагад суралцах эрхтэй болсон байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ГЭР БҮЛИЙН ГИШҮҮНИЙ нэг хүний сургалтын төлбөрийг Боловсролын зээлийн сан хариуцна.	Саналыг тусгасан
149.	10.3.Энэ хуулийн 10.1-д заасан сурах бичиг, сургалтын боломжит тохируулга, дэмжих үйлчилгээний жагсаалт, зардлын хэмжээ, олгох журмыг боловсрол, эрүүл мэнд хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батална.	Саналыг тусгасан
150.	10.6.Хөгжлийн бэрхшээлтэй хүнд мэргэжлийн чиг баримжаа, ур чадвар олгох үйл ажиллагааг дагнан явуулж байгаа мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны зардлыг улс, орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх ба жишиг зардлыг тооцох журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлан хэрэгжүүлнэ.	Боловсролын холбогдох хуульд энэ зохицуулалт тусгагдсан
151.	13.1.1.хөгжлийн бэрхшээлтэй хүнд нэн шаардлагатай үзүүлэх ажил, мэргэжлийн жагсаалтыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага 5 жил тутамд гаргах;	Саналыг тусгасан
152.	13.2. Өмчийн бүх хэлбэрийн их, дээд сургууль, коллежийн ерөнхий эрдмийн болон суурь хичээлийн төлөвлөгөө, хөтөлбөрт хөгжлийн бэрхшээл, хүний ялгаатай байдал, хүний эрх тухай ойлголт, мэдлэг өгнө.	Саналыг тусгасан
“Эрхэм нандин сувд” ТББ		
153.	Хүүхэд хамгааллын тухай хуулинд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тухай ороогүй байна	

154.	Хуулийн 4.1.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүн, Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд гэсэн өөр өөр нэр томъёог тодорхой болгох уг хуулийн 15.1.10 дээр 3-уулаа оржээ эсвэл : 1. Хөгжлийн бэрхшээлтэй хүн 2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн 3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд гэж тус тусдаа хэн бэ. гэж тодотгож оруулах	“4.1.1.“хөгжлийн бэрхшээлтэй хүн” гэдэгт бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны болон хандлагын бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн харилцаанд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох боломж нь хязгаарлагдсан хүүхэд, насанд хүрэгчийг” гэж томъёоллоо.
155.	Хөгжлийн бэрхшээлийн талаар нийгэмд мэдлэг ойлголт өгөхийн тулд цэцэрлэг сургуулийн хичээлийн хөтөлбөрт тодорхой цагаар хичээл ордог байх эсвэл анги хамт олонд хичээлийн бус цагаар нэмэлт таниулан мэдээлэх	Хуулийн төслийн 9-р зүйлд энэ агуулга туссан байгаа
156.	Тулгуур эрхтний тухай өөрчлөлт яаж орсныг асуух	Туслах технологи, асаргаа сувилгааны хэрэгсэл, ариун цэвэр-эрүүл ахуйн материалаар хангах боломжийг бүрдүүлсэн.
157.	9 дүгээр зүйл.Сурч боловсрох эрхэд “Чадварт тохирсон” гэж нэмэх	Хэрэгцээнд нь нийцүүлэхийн тулд тухайн хүний чадварыг нь харгалзах ёстой. Хэрэгцээнд нийцсэн гэсэн байдлаар тусгасан.
158.	- Хөгжлийн бэрхшээлтэй Гишүүн, байнгын асаргаа шаардлагатай өрхийн нэг суралцагчийн /хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй хүмүүсийн аав ээжийн аль нэг нь ажил хийх боломжгүй болдог./ - хөдөлмөрийн чадвараа алдсан гишүүнтэй гэдгийг хасаад ХБ тэй иргэнтэй гэж оруулах	Саналыг тусгав
159.	- Тусгай сургууль гэж боловсролын хуулинд байгаа эсэхийг тодруулах - Боловсролын шинэ хуулинд тусгай сургууль гэх ойлголт байхгүй болсон. 10.5 -ийг засах шаардлагатай	Саналыг тусгав.
160.	ХБХүнд эрүүл мэндийн тусламж , үйлчилгээг цаг алдалгүй чанартай тэгш хүртээмжтэй хүргэж, шаардлагатай тохиолдолд амь насанд аюул учирч болзошгүй үед хамгийн ойр байгаа бүх шатны эрүүл мэндийн байгууллага тусламж үзүүлж эмнэлэг хоорондийн гэрээгээр дараагийн шатны эрүүл мэндийн байгууллагад хүлээлгэн өгөх гэж оруулах.	Энэ асуудал холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжиж байгаа
161.	17 дугаар зүйл.Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ Зөвхөн Хөгжлийн БЭРХШЭЭЛТЭЙ хүүхдийн тухай юм уу?	Хөгжлийн бэрхшээлтэй хүн буюу хүүхэд болон насанд хүрэгчдийн асуудлыг авч үзсэн.
162.	17 дугаар зүйл.Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ-д Хөгжлийн бэрхшээлтэй хүнд амь насны заалтаар учирч буй аюулт тохиолдолд яаралтай тусламжийг хамгийн ойр байгаа бүх шатны эрүүл мэндийн байгууллага үзүүлээд эмнэлэг хоорондын гэрээгээр дараагийн шатны эрүүл мэндийн байгууллагад хүлээлгэн өгөх гэж нэмэх	Энэ асуудал холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжиж байгаа
163.	19 дүгээр зүйл.Олон нийтэд түшиглэн хамруулан хөгжүүлэх үйлчилгээ 19.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг олон нийтэд түшиглэн хамруулан	Хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх үйлчилгээний нэг чиглэл нь “19.1.1.өвчин, эмгэг, гэмтэл, бэртлийн улмаас үүссэн

	хөгжүүлэх үйлчилгээг дараах чиглэлээр үзүүлнэ: 19.1.1. өвчин, эмгэг, гэмтэл, бэртлийн улмаас үүссэн үр дагаврыг арилган хэвийн байдалд оруулахад чиглэсэн эрүүл мэндийн чиглэл гэснийг Эрүүл мэндийн нөхөн сэргээх чиглэл гэж өөрчлөх	үр дагаврыг арилган хэвийн байдалд оруулахад чиглэсэн эрүүл мэндийн” чиглэл юм. Энэ чиглэлийн хүрээнд үзүүлэх үйлчилгээ нь нөхөн сэргээхээс гадна эмчлэх, эрүүлжүүлэх зэрэг үйлчилгээ багтана. Иймд энэ саналыг хүлээн авах боломжгүй байна.
164.	19.1.2. хөгжлийн бэрхшээлтэй хүн бусдын адил боловсрол, мэргэжил эзэмшихийг дэмжих боловсролын чиглэл гэснийг Боловсрол эзэмших, хөгжлийг дэмжих гэж оруулах	Хуульд Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг олон нийтэд түшиглэн хамруулан хөгжүүлэх үйлчилгээ гэж заасан учир боловсролын чиглэлийг “Боловсрол эзэмших, хөгжлийн чиглэл” гэж нэрлэх шаардлагагүй юм.
165.	22.1.4.байнгын асаргаа шаардлагатай “хөгжлийн бэрхшээлтэй хүн” гэснийг “иргэн” гэж оруулах	Хуулийн 4.1.1-д ...хүүхэд, насанд хүрэгч” гэж тодуулсан учир энэ саналыг тусгах шаардлагагүй
166.	22.1.6. хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн болон байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй “хүний” гэснийг “иргэний” гэж өөрчлөх	Хуулийн 4.1.1-д ...хүүхэд, насанд хүрэгч” гэж тодуулсан учир энэ саналыг тусгах шаардлагагүй
167.	22.1.9. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд хүүхдийн зусланд амарвал эрхийн бичгийн төлбөрийг жилд нэг удаа 100 хувиар олгох гэсэн зохицуулалтад эх хүүхдийн амралт гэж нэмэх	“22.1.9.хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд хүүхдийн зуслан, харгалзан дэмжигчийн хамт эх, хүүхдийн амралтад амарвал жишиг үнийг харгалзан хүүхдийн эрхийн бичгийн төлбөрийг 100 хувиар, харгалзан дэмжигчийн төлбөрийг 50 хувиар жилд нэг удаа олгох;” гэж саналыг тусгалаа.
168.	22.1.10. хөгжлийн бэрхшээлтэй 18 хүртэлх насны хүүхдийн дотоодод хийлгэсэн туслах бүтээгдэхүүний үнийг эдэлгээний хугацаа дууссан болон тухайн хүүхдийн өсөлтийн улмаас бие эрхтэнд нь таарахгүй болсон тохиолдолд тухай бүр жишиг үнийг баримтлан нөхөн олгох гэсэнд “дотоодод хийлгэсэн болон Худалдан авсан туслах хэрэгсэл” гэсэн агуулгыг тусгах	Саналыг тусгав
169.	22.8.2. асаргаа сувилгааны хэрэгсэл, ариун цэвэр-эрүүл ахуйн материалд “живх”-ийг нэмж тусгах	Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд тусгахаар санал боловсруулсан.
170.	24.2. Төрөөс үзүүлж буй эрүүл мэнд, боловсролын үйлчилгээ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үнэ төлбөргүй байна. гэсэнд нийгмийн халамжийн үйлчилгээ гэж нэмэх\	Нийгмийн халамжийн үйлчилгээг бүхэлд нь үнэ төлбөргүй үзүүлдэг тул энэ саналыг тусгах шаардлагагүй
171.	24.4.Энэ хуулийн 24.3-д заасан төвөөр дараах гэсний дараа “дэмжих” гэж нэмэх	Төслийн 24.3-т “дэмжлэг үйлчилгээ” гэж тусгагдсан тул энэ саналыг тусгах шаардлагагүй
172.	24.4.Энэ хуулийн 24.3-д заасан төвөөр дараах үйлчилгээг үзүүлнэ: 24.4.5. асаргаа үйлчилгээ-д Хүүхдийн бэрхшээлээс хамаарч хүүхдийг хооллох, бие засуулах, асрах бүх төрлийн үйлчилгээг мөн авч үзэх	Хүний анхдагч хэрэгцээг хангахад чиглэсэн хооллох, бие засахад дэмжлэг үзүүлэх нь хуульд заасан үйлчилгээг үзүүлэх явцад давхар явагдана. Иймд үүнийг нарийвчлан тусгах шаардлагагүй юм
173.	24.4.6. сэргээн засах болон боловсрол,хөгжлийн цогц үйлчилгээ. Сэргээн засах, боловсрол, хөгжлийн болон нийгэмшүүлэх, асаргаа үйлчилгээ бүхий цогц үйлчилгээ	Нийгэмшүүлэх, асрах үйлчилгээг хуульд заасан үйлчилгээтэй хамтад үзүүлнэ.

174.	24.7.Энэ хуулийн 24.3-д заасан төвийн үйлчилгээ, үйл ажиллагааны зардлыг аймаг, нийслэл, дүүргийн тухайн жилийн төсөвт тусган санхүүжүүлнэ гэжээ. - Боловсролын тухай хуулинд салбар дундын санхүүжилтээс гэсэн байгааг тодруулж харах - санхүүжилтийг хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийг дэмжих сангаас гаргах гэж оруулах	Боловсролын ерөнхий хуулийн 17.9-д заасан дэмжих төв нь боловсрол эзэмшихэд дэмжлэг үзүүлэх төв юм. Тус хуульд туссан төв нь хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд сэргээн засах үйлчилгээ үзүүлэхэд чиглэнэ. Иймд эдгээр төвийн зардлыг аймаг, нийслэлийн төсөвт тусгах нь зүйтэй гэж үзсэн болно.
175.	Хуулийн 24.9. гэрээлэн гүйцэтгүүлнэ гэснийг гүйцэтгүүлж болно гэх	Саналыг тусгав
176.	24.12. Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа шалтгаанаар хөдөлмөр эрхлээгүй эх /эцэг/-ийн Эрүүл мэндийн даатгалыг холбогдох хуульд заасны дагуу төрөөс бүрэн хариуцна гэсэн байна. Тэтгэврийн даатгалыг гэж нэмж оруулах	Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 4.1.5."нийгмийн даатгал" гэж даатгуулагч, ажил олгогч, төрөөс хуульд заасны дагуу нийгмийн даатгалын санд урьдчилан шимтгэл төлж сан бүрдүүлэх, даатгуулагч өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа алдах, жирэмсний болон амаржсаны амралт эдлэх, ажилгүй болоход өөрт нь, хэрэв даатгуулагч нас барвал түүний асрамжид байсан гэр бүлийн гишүүнд хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардлын төлбөр олгох, ажил олгогчид үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал олгох, шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх нийгмийн хамгааллын арга хэмжээг;" 4.1.11."нийгмийн даатгалын шимтгэл төлөгч" гэж энэ хуульд заасны дагуу нийгмийн даатгалын санд шимтгэл төлөх үүрэг хүлээсэн даатгуулагч, ажил олгогч, төр, хуулийн этгээдийг;" гэж тодорхойлсон. Байнгын асаргаа шаардлагатай хүүхдээ асарч байгаа эх /эцэг/ нь нийгмийн даатгалын харилцаанд орохгүй байгаа учир тэтгэврийн даатгалыг төрөөс хариуцах зохицуулалтыг тусгах боломжгүй. Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авах эрх үүсээгүй иргэд тэтгэврийн насанд хүрэхэд нийгмийн халамжийн тэтгэвэр авах эрх үүснэ.
177.	24.14. Монгол Улсын олон улсын гэрээнд зааснаар байнгын асаргаа шаардлагатай 8 насанд хүрсэн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг, эх, эсхүл хууль ёсны асран хамгаалагчийн зөвшөөрөл, хүсэлтээр 21 насанд хүртэл нь энэ хуульд заасан боловсролын болон асрамжийн үйлчилгээнд хамруулж болно. Энд Сэргээн засах, боловсрол хөгжлийн болон нийгэмшүүлэх асаргаа үйлчилгээ гэж нэмэх	Сэргээн засах үйлчилгээг нас харгалзахгүйгээр насан турш нь үнэ төлбөргүй үзүүлж байгаа учир саналыг тусгах шаардлагагүй
178.	Хуулийн 33.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бүртгэж, үнэмлэх олгоно гэснийг хөгжлийн бэрхшээлтэй иргэн ба хүүхдэд үнэмлэх олгох гэж тодруулж оруулах	Хөгжлийн бэрхшээлтэй хүн гэсэн тодорхойлолтод хүүхэд, насанд хүрэгч аль аль нь багтаж байгаа учир "...иргэн ба хүүхэд" гэж тусгах шаардлагагүй
Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг, эхчүүдийн холбоо		

179.	Хуулийн 43.1 гэж нэмэлтээр Хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй, өөрийгөө бүрэн илэрхийлэх боломжгүй ХБХ -ийг төлөөлөн асран хамгаалагч гомдол гаргах эрхтэй гэж оруулах.	43.1-т энэ агуулга туссан
180.	4.1.12. Дэмжих үйлчилгээний тодорхойлолтыг оруулья	Тусгах шаардлагагүй
181.	5.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалахад дараах зарчмыг баримтална гэсэн агуулгад Эцэг эх, асран хамгаалагчийн төлөөллийн оролцоог хангах	Хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудлыг зохицулна
182.	- Асуулт: ялгаварлан гадуурхсан гэдгийг яаж баталгаажуулах вэ? - САНАЛ: Ялгаварлан гадуурхсан тохиолдолд Эрүүгийн хэргийн тухай хуульд зааснаас бусад хэлбэрээр хариуцлага тооцдог болох \жич: захиргааны, зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах замаар торгууль оногдуулдаг болгох, жишээ нь Хүүхдийн эрхийн байцаагч Хүүхдийн эрхийг зөрчсөн этгээд, байгууллагад 3 хүртэл сая төгрөгийн торгууль тавьдаг эрхтэй байна. ХБХүний эрхийн байцаагч гэдэг хүн эсвэл өөр хэн нэгэн эрх бүхий хүн Торгууль тавьдаг эрхийг нээж өгөх гм\	Зөрчлийн хуулиар энэ асуудлыг зохицуулж байгаа
183.	7.1.1-д 3 жил гэснийг 1 жил болгох. Тайлбар : Боловсон хүчний тогтворгүй байдлаас шалтгаална	3 жилийг хэвээр үлдээв
184.	9.2.Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн нас, хэл, соёлын онцлогт тохирсон сургалтын хөтөлбөрийг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.гэснийг эсэргүүцэж байна. Сургалтын хөтөлбөр бүх хүүхдэд нэг байх бөгөөд ГСТөлөвлөгөөгөөр хувь хүний ялгаатай хэрэгцээнд нийцүүлэн хувь хүний хөгжлийн төлөвлөлт хийдэг олон улсын жишигтэй. Ингэж зөвхөн ХБХдэд насаар нь, хэлээр нь, соёлын ялгаатай байдлаар нь сургалтын хөтөлбөр боловсруулах нь буруу.	Саналыг тусгасан
185.	10.2. суралцагчийн сургалтын төлбөрийг боловсролын зээлийн сангаас санхүүжүүлнэ гэснийг төр хариуцна гэж өөрчлөх	Саналыг тусгасан
186.	10.4-т Бэрхшээлийн онцлогт тохирсон мэргэжлийн сургалтын нэр төрлийг нэмэгдүүлэх, ажлын байртай болгох. хяналтыг эрх бүхий байгууллага, эцэг эхийн оролцоотойгоор тавих.	Хяналт тавих асуудал өөр зүйлээр зохицуулагдана
187.	15.1.9-д бас хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийг дэмжих санг нэмэх	Саналыг тусгав
188.	17 дугаар зүйл.Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авахад дараалал харгалзахгүй үйлчилгээ үзүүлэх гэсэн агуулгыг тусгах	Цаг алдалгүй гэсэн агуулгаар тусгасан
189.	21.5.Хөгжлийн бэрхшээлтэй хүн өндөр насны тэтгэвэр тогтоолгоход түүний авч байсан нийгмийн халамжийн тэтгэврээс багаар тогтохоор бол түүний ажилласан жилийг үл харгалзан авч байсан тэтгэврийг хэвээр нь олгох ба Нийгмийн халамжийн тухай хуульд заасан арга	“21.5.Хөгжлийн бэрхшээлтэй хүн нийгмийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр тогтоолгосон бол Нийгмийн халамжийн тухай хуульд заасан тэтгэврээс бусад арга хэмжээнд үргэлжлүүлэн хамрагдана.” Гэж найруулсан

	хэмжээнд үргэлжлүүлэн хамрагдана гэсэнд хөгжлийн бэрхшээлтэй иргэн сайн дурын даатгалд оруулдаг болгох гэсэн агуулгыг нэмэх	
190.	22.8.1-д Байнгын асаргаатай хөгжлийн бэрхшээлтэй иргэн 100%гэж нэмэх	Хуулийн төслийн 22.8.1.в-д 50 хувь гэж оруулсан
191.	24.12-т Хүүхэд наснаас нь эхлэн байнгын асаргаатай байсан хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч байгаа шалтгаанаар хөдөлмөр эрхлээгүй эх эцгийн тэтгэврийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг төрөөс бүрэн хариуцна гэж нэмэх	Тэтгэврийн даатгалыг шимтгэлийг төр хариуцах боломжгүй
192.	28.2.4.бие даан амьдрахад бэлтгэх түр байрлуулах үйлчилгээ-д бүлгээр амьдрах үйлчилгээг нэмэх	Түр амьдрахад ганцаар, бүлгээр амьдрах нь үйлчилгээнд хамрагдагчдын асуудал учир энд тусгах шаардлагагүй
"Тэгш нийгэм холбоо" ТББ		
193.	Хуулийн төслийн заалтуудад орсон "олон нийт" гэснийг "нийгэм, хамт олон" гэдэг нэр томъёогоор солих	Хамт олон гэж өөрчилсөн
194.	40 дүгээр зүйл. Төрийн бус байгууллагад тавигдах шаардлага, нийтлэг эрх, үүрэг 40.2.1. дэх хэсэгт нэмэлт оруулах: Холбогдох хууль тогтоомж, төрийн байгууллага, албан тушаалтны гаргасан шийдвэр, бодлого, хөтөлбөр, үйл ажиллагааны үйл ажиллагааны хэрэгжилтэд хөндлөнгийн хяналт тавих зорилгоор хараат бус хяналтын механизм байгуулах	хараат бус хяналтын механизм байгуулах гэсэн санааг тусгах боломжгүй
"Гэрэлт ирээдүй" ТББ		
195.	- Бэлтгэдэг тусгай газар бий эсэх, эсвэл бэлтгэх газар бий болгох эсэх - Харааны бэрхшээлтэй нэг ч хүн нохойтой туршлага байхгүй. Цаашид энэ асуудлаар бус хүүхдийн хөтөч болон туслах багшийн асуудлыг нарийвчлан анхаарч хөгжүүлэх сайжруулах талаар ажиллаж, хуульд тусгах шаардлагатай байна.	Журмаар шийдвэрлэнэ
196.	7 дугаар зүйлд Байгууллагын сургалтыг хэн хийх вэ? Хаанаас санхүүжих вэ? Үр дүнг нь хэрхэн тооцох вэ? Гэдгийг тусгах	Журамд тусгана
197.	7.1.1-д БШУЯ хамтрах шаардлагатай байна. Ямар ч уялдаагүй явж ирсэн учир үр дүн сайн биш байна.	Журамд тусгана
198.	8.1-д Холбогдох мэргэжлийн байгууллагуудаа тодорхой дурдаж, хамтын ажиллагааны гэрээ байгуулж, ажил хэрэг болгох талаас нь нарийн зааж хэрэгжүүлэх шаардлагатай. Бүрхэг байна.	Салбарыг ерөнхийлөн тусгасан. Байгууллагын нэрийг хуульд оруулах боломжгүй
199.	9.6-д байгууллагаа тодруулах, албажуулах, үр дүн хэрэгтэйгээс гадна хүүхдийн асуудлыг тод томруун тодорхой тусгах	Байгууллагын нэрийг хуульд оруулах боломжгүй
200.	10.2-т БЗС хамтран ажиллах, энэ заалтыг завал оруулж, ХБ хүүхдийг өөрийг нь зохих цагт нь дэмжих шаардлага байна. Орхигдуулмааргүй байна.	Саналыг тусгасан
201.	10.3-т заалтыг заавал оруулна уу? Өнөөг хүртэл ийм зээл авсан сурсан туршлага байхгүй байна.	Саналыг тусгасан

202.	10.4 Энэ асуудал гуован яам хоорондын хамтын ажиллагааны нийцэл байхгүйгээс үргэлж орхигдож ирсэн. Энэ асуудлыг шийдвэрлэх гарц, хариуцах газар, санхүүгийн эх үүсвэрээ тодорхой болгож, ажил хэрэг болгоход нь ахиц дэвшил гаргаачээ	Саналыг хүлээн авлаа. Хэрэгжилтэд анхаарна
203.	12.1 Тусгай сургууль болон энгийн сургуулийн ялгааг тодорхой тусгах. Энгийн сургуульд брайль үсэг мэддэг заах чадвартай багш байхгүй. Брайль бичгийг бага ангид нь зааж сургах шинэ орчин үелэг хөтөлбөр боловсруулахгүй бол 1950 оны стандартаараа явах нь хөгжлийн хоцрогдол шүү.	Боловсролын хууль тогтоомжид тусгай сургууль гэсэн нэр томъёо ороогүй
204.	12.2 Энэ байгууллагаа тодорхой болгож, стандартыг шинэчлэн ажиллахад мэргэшсэн мэргэжилтэнүүд, эрдэмтдийн хамтрал зайлшгүй гэдгийг тусган хуульчлах нь зүйтэй.	Хэрэгжилтэд анхаарна
205.	15.1.4. Энэ заалтанд хүүхдийг тусгах шаардлагатай. Бүх талбарт ХБ хүүхэд орхигдоод байна.	Хуулийн төслийн “4.1.1. хөгжлийн бэрхшээлтэй хүн хүүхэд, насанд хүрэгчийг” гэж тодорхойлсон. Иймд энэ агуулгад хүүхэд мөн туссан
206.	17.2 Ямар бэрхшээлд ямар техник тоног, төхөөрөмж өгөгдөх нь тодорхой зааглах, Бэрхшээл бүр өөр өөрийн онцлогтой тул асар их ялгаатай хэрэгцээ байдгийг мартаж болохгүй	Журмаар зохицуулна
207.	20.2 - Энд хүүхдийг орхигдуулсан байна. Энэ байгууллага нь тодорхой байх шаардлагатай.	Хуулийн төслийн “4.1.1. хөгжлийн бэрхшээлтэй хүн хүүхэд, насанд хүрэгчийг” гэж тодорхойлсон. Иймд энэ агуулгад хүүхэд мөн туссан
208.	21.3.2 дэмжлэг нь мөнгөн дэмжлэг үү, тодруулах	Журмаар зохицуулна
209.	21.4 хөтөлбөрийг хэн боловсруулах вэ?	Хэрэгжилтийн асуудал. Засгийн газрын тухай хуульд тодорхой байгаа
210.	22.1.1 аль сангаас олгохыг заах	Хуулийн төслийн 22.1-д нийгмийн халамжийн сангаас гэж тодорхой заасан
211.	22.1.2. Нийслэл орон нутагт хэрхэн хэрэгжих талаарх заалт хэрэгтэй	Журмаар зохицуулна
212.	22.1.8. Бүх аймаг орон нутагт хэрэгжүүлэх 22.1.9	Орон нутагт хэрэгжиж байгаа
213.	22.1.9 Нэр заасан зуслан уу? Аль ч зуслан байж болох уу?	Хүүхдийн зуслан, эх хүүхдийн амралт гэж тусгасан
214.	22.1.12. Сарын тэтгэмж л олгох уу?	Хуулийн төслийн 22.1.12-т “...түүний оролцсон тэмцээний давтамжийн хугацаанд ногдох нийгмийн халамжийн тэтгэвэртэй тэнцэх хэмжээний тэтгэмж” гэж тодорхой тусгасан
215.	22.1.14. Хүүхдийг орхигдуулсан байна. Харааны бэрхшээлтэй хүүхдүүдэд энэ зардал нэн шаардлагатай.	
216.	24.4.2. Олон улсын оюуны тэмцээн уралдаанд оролцох зардал, IELTS өгөх төлбөр, сурагч солилцоогоор гадаад улсад явах зардал зэргийг тусгах	Энэ саналыг 24.4.2-т тусгах боломжгүй
217.	26.1 Сонгуулийн ерөнхий хороо тэгш үйлчилгээ үзүүлэх талаар тусгах уу?	Сонгуулийн тухай хуулиар Сонгуулийн ерөнхий хорооны чиг үүргийг тогтооно.

218.	28.2-т - Туслах болон хөтөч багшийн асуудлыг тусгаачээ. Нохой биш багш авмаар байна. - Амьдрах орчин нөхцөл нь бүрдсэн, бие даан амьдрах боломжтой орон байрыг барьж байгуулан хангах талаар тусгах	Хувийн туслахын үйлчилгээ туссан
219.	29.2.4 Шагнал урамшууллаа хаанаас хэрхэн өгөхийг тусгах	Биеийн тамир, спортын тухай хуулиар зохицуулж байгаа
220.	30.2.1 Хүүхдийн асуудлыг тусгаачээ	Хуулийн төслийн “4.1.1. хөгжлийн бэрхшээлтэй хүн хүүхэд, насанд хүрэгчийг” гэж тодорхойлсон. Иймд энэ агуулгад хүүхэд мөн туссан
221.	30.2.2. Хүүхэд яах вэ?	Хуулийн төслийн “4.1.1. хөгжлийн бэрхшээлтэй хүн хүүхэд, насанд хүрэгчийг” гэж тодорхойлсон. Иймд энэ агуулгад хүүхэд мөн туссан
222.	34.1.2. Хаанаас батлаж, хэрхэн санхүүжүүлэх вэ?	УИХ-ын тогтоолоор санхүүжүүлэх эх үүсвэрийг заана.
223.	37.1. Илүү данхар төсөвтэй байгууллага нэмж байгуулах зорилго юу байна. ХБХХЕГ байхад хангалттай биш үү?	Салбар хоорондын зохицуулалт хийх чиг үүрэгтэй зөвшилцөх бүтэц юм. Байнгын ажиллагаатай биш учир “данхар” төсөв гарахгүй
224.	38.1.5. - Хүүхдийг байнга орхигдуулж байна. - Хэрхэн дэмжих вэ?	Хуулийн төслийн “4.1.1. хөгжлийн бэрхшээлтэй хүн хүүхэд, насанд хүрэгчийг” гэж тодорхойлсон. Иймд энэ агуулгад хүүхэд мөн туссан
225.	42.1.1 Энэ ажилтан нь өөрөө хөгжлийн бэрхшээлтэй хүн байх эсэх нь тодорхой байх	хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах төрийн үйлчилгээний салбарын ажилтан заавал хөгжлийн бэрхшээлтэй байх шаардлагагүй бөгөөд энэ салбарт ажиллагчдад энэ зохицуулалт үйлчилнэ.

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ